

БАТЛАВ.
"ДЦС-3" ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ

..... /Г.ДАМДИНСҮРЭН/

УЛААНБААТАР ХОТ
ТТ28512-5672-405

БАТЛАВ.
"БАЯН СӨӨГТ" ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

..... /Ц.ЧАНЦАЛДУЛАМ/

УЛААНБААТАР ХОТ
ТТ28512-5672-405

**ЗАХИРГААНЫ ГАДНА ТОХИЖИЛТЫН ХЭСЭГ БОЛОН
ТӨМӨР ЗАМ ДАГАСАН МОДЫГ ХЭЛБЭРЖҮҮЛЭН ЗАСАХ, ТАЙРАХ
АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ**

2017 оны 04-р сарын 24-ны өдөр

№ 1-4-196/17

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас "ДЦС-3" ТӨХК-ийг төлөөлж Тэргүүн дэд захирал, Ерөнхий инженер Ү.Төмөрхуяг, /цаашид "захиалагч" гэх/, нөгөө талаас "Баян сөөгт" ХХК-ийг төлөөлж агрономич Д.Наранчимэг /цаашид "гүйцэтгэгч" гэх/ нар Монгол улсын Иргэний хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг үндэслэн дараах нөхцлийг харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү гэрээний зорилго нь "ДЦС-3" ТӨХК-ийн Захиргааны гадна тохижилтын хэсэг болон төмөр зам дагасан мод, бургасыг технологийн дагуу хэлбэржүүлэн засах, тайрах, огтлох, гэрээнд заасан хугацаанд нь хүлээлгэн өгөх, төлбөр тооцоог барагдуулах харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Ажил гүйцэтгэх ерөнхий хугацаа нь 2017 оны 04 -р сарын 24 ны өдрөөс 2017 оны 05-р сарын 08-ний өдөр хүртэл байна. Гэрээт хугацааг тогтоохдоо хуанлийн тооллыг удирдлага болгоно.

Хоёр. Ажлын хөлс, түүнийг гүйцэтгэх арга зам

- 2.1 Гэрээгээр гүйцэтгэх ажлын хөлс 9,900,000.00 /есөн сая есөн зуун мянга/-н төгрөг /НӨАТ-гүй/ байна.
- 2.2 Ажлын хөлсний төлбөрийг ажил хүлээлцэж, гэрээ дүгнэсэн акт батлагдсанаас хойш ажлын 10 хоногт багтаан гүйцэтгэгчийн дансанд нэхэмжлэхээр шилжүүлнэ.

Гурав. Ажил гүйцэтгэгчийн эдлэх эрх, хүлээх үүрэг

- 3.1 Ажил гүйцэтгэгч нь дараах эрх эдэлнэ:
 - 3.1.1 Захиалагчаас батлагдсан төсвийн дагуу гэрээнд заасан хугацаанд санхүүжилт хийхийг шаардах;
 - 3.1.2 Захиалагч зохих ёсоор гүйцэтгэсэн ажлын үр дүнг хугацаанд нь хүлээн авах үүргээ биелүүлээгүй бол ажлын үр дүнг хүлээн авсанд тооцож хөлс төлөхийг шаардах;
- 3.2 Ажил гүйцэтгэгч нь дараах үүрэг хүлээнэ:
 - 3.2.1 Гэрээт хугацаанд мод хэлбэржүүлэлтийн ажлыг батлагдсан төсөвт багтаан агротехникийн дагуу чанартай, үзэмжтэй хийж гүйцэтгэх;
 - 3.2.2 Гэрээт ажил гүйцэтгэх ажилтнууддаа аюулгүй ажиллагааны өдөр тутмын зааварчилгаа тогтмол өгч, ажлын байрны аюулгүй байдлыг ханган хүн нэг бүрт хамгаалах хэрэгслэлийг иж бүрэн хэрэглүүлэх, зориулалтын шат тавцанг зориулалтын дагуу ашиглаж осол гаргахгүй ажиллуулах ба галын аюулгүй байдал, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг Гүйцэтгэгч тал бүрэн хариуцна.

Handwritten signature

Handwritten mark

Дөрөв. Захиалагчийн эдлэх эрх, хүлээх үүрэг

4.1 Захиалагч нь дараах эрх эдэлнэ:

4.1.1 Мод хэлбэржүүлэлтийн ажлын явцад хяналт тавих, технологи зөрчсөн гэж үзвэл ажлыг зогсоож, зөрчлийг засуулан ажлыг дахин эхлүүлэх эрхтэй;

4.1.2 Гүйцэтгэсэн ажилд ямар нэг доголдол байвал гүйцэтгэгчээр нөхөн хийлгэх эрхтэй;

4.2 Захиалагч нь дараах үүргийг хүлээнэ:

4.2.1 Ажил гүйцэтгэгчид 2.1, 2.2-д заасны дагуу санхүүжилтийг хийнэ.

Тав. Талуудын хүлээх хариуцлага

5.1 Захиалагч тал гүйцэтгэгчээс ажлыг актаар хүлээн авахдаа гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй гэж үзвэл гүйцэтгэгчээр ажлыг дахин хийлгэнэ.

5.2 Гүйцэтгэсэн ажлын үр дүнг захиалагчид шилжүүлэхээс өмнө гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас тухайн ажлын үр дүн устсан гэмтсэн тохиолдолд бий болох эрсдлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу захиалагч, гүйцэтгэгч тал хамтран хариуцна.

Зургаа. Гэрээг цуцлах

6.1 Нэг талын буруутай үйлдлээс шалтгаалж гэрээг цуцалсан бол буруутай талаас учирсан хохирлоо нөгөө тал нь шаардан гаргуулах, эсвэл ажлын хөлс олгохоос татгалзах, хэмжээг буруулах эрхтэй.

6.2 Талуудын аль нэг нь гэрээний үүргээ зөрчсөн бол үүрэг гүйцэтгэх 3 хүртэлх хоногийн хугацаа тогтоох ба үр дүн гараагүй тохиолдолд гэм буруугүй тал нь гэрээнээс татгалзах эрхтэй.

Долоо. Бусад

7.1 Энэхүү гэрээг биелүүлэхтэй холбоотой аливаа маргаан, санал зөрчилдөөн зэрэг асуудлыг талууд эвийн журмаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

7.2 Хэрэв хоёр тал эвээр шийдвэрлэж чадахгүй бол Монгол Улсын шүүхээр уг асуудлаа шийдвэрлүүлнэ.

7.3 Талууд харилцан тохиролцож гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болох ба өөрчлөлтийг бичгээр үйлдэж баталгаажуулна.

7.4 Гэрээг 4 хувь үйлдэж, захиалагч тал 3 хувь, гүйцэтгэгч тал 1 хувь авах бөгөөд хувиуд ижил тэгш хүчинтэй байна.

ТАЛУУДЫН ХАЯГ:

ЗАХИАЛАГЧ:

УБ, ХУД 3-р хороо, Чингисийн өргөн чөлөө, "ДЦС-3" ТӨХК, өөрийн байр.

ГҮЙЦЭТГЭГЧ:

УБ, ХУД 2-р хороо, 19 хороолол, 35 б, 20 тоот
РД:5672465
Утас: 99829156, 99898979

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

"ДЦС-3" ТӨХК-ИЙН ТЭРГҮҮН ДЭД
ЗАХИРАЛ, ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР
 /У.ТӨМӨРХУЯГ/

ТХХ-ИЙН ДАРГА
 /Д.ТӨМӨРБААТАР/


СБХ-ИЙН ДАРГА
 /Л.ДОРЖХОРЛОО/

ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ
 /М.ЧУЛУУНЧИМЭГ/

ГЭРЭЭНИЙ МЭРГЭЖИЛТЭН
 /Г.БАТНЯМ/

ХУУЛИЙН МЭРГЭЖИЛТЭН
 /М.ЭНХЗУЛ/

"БАЯНСӨӨГТ" ХХК-ИЙН АГРОНОМИЧ

 /Д.НАРАНЧИМЭГ/